



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/225

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 1.3.8, 1.6 дахь заалт, Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны 2026 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 01/984 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн “Амьжиргааны зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А/440 дүгээр тушаалын нэгдүгээр заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулсугай.

“Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдад Боловсролын зээлийн сангаас олгох амьжиргааны зардлын хэмжээг 2025-2026 оны хичээлийн жилд (2025 оны 9 дүгээр сарын 1-ээс 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл) нэгдүгээр хавсралтаар, 2026 оны 9 дүгээр сарын 1-ээс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хоёрдугаар хавсралтад заасан хэмжээгээр олгохоор тус тус шинэчлэн баталсугай.”

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын зээлийн сан (П.Зохихсүрэн), хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны газар (Б.Энхбаяр), төсвийн хуваарьт зохицуулалт хийхийг Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газар (А.Мөнх-Оргил)-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010706

Боловсролын сайдын 2026 оны 8
дугаар сарын 18 өдрийн А/440
дугаар тушаалын хавсралт

Боловсролын сайдын 2025 оны 9
дүгээр сарын 10-ны өдрийн А/440
дүгээр тушаалын хоёрдугаар
хавсралт

ATA12937 9116621 9024070582

АМЬЖИРГААНЫ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Улс	Нэг сард олгох хүнэний зардал (ам.доллараар)	Нэг сарын байрны төлбөр	Олгох валют
1	Австрали	440	2,070.00	USD
2	Их Британи	440	2,120.00	USD
3	Герман	440	450.00	EUR
4	Франц	440	725.00	EUR
5	ОХУ	310	750.00	USD
6	Польш	440	300.00	EUR
7	Румын	440		
8	Унгар	440	630.00	EUR
9	Чех	440	528.00	EUR
10	Канад	440	1,290.00	USD
11	АНУ	440	1,800.00	USD
12	Австри	440	650.00	EUR
13	БНСУ	440	460.00	USD
14	Япон	440	500.00	USD
15	Тайвань	440		
16	БНХАУ	310	260.00	USD
17	Вьетнам	310		
18	Лаос	310		
19	Литва	310	150.00	EUR
20	Энэтхэг	310	250.00	USD
21	Казахстан	310		
22	Болгар	310		
23	Беларусь	310		
24	Тайланд	310		
25	Куба	310		
26	Өвөрмонгол	310		
27	Турк	440	470.00	USD
28	Сингапур	440	830.00	USD